



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1/239

Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авах  
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” А/116 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хороодын хэсгийн ахлагч нарт компьютер, тоног төхөөрөмж (Улаанбаатар Чингэлтэй дүүрэг)-ийг нийлүүлэх НХААГ-21/025 дугаартай нийлүүлэгчээр сонгон шалгарсан “Бодь Электроникс” ХХК-аас нийлүүлэх хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2.Чингэлтэй дүүрэгт нийлүүлэгдэж буй компьютер, тоног төхөөрөмжийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Н.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

**115050000727**

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 1129 дугаар тушаалын хавсралт



### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Мандах	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Түвшинтөр	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн Орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Б.Энхзаяа	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасгийн Дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Х.Халиун	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасгийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Б.Эрдэнэмөнх	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн